



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/628

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дотоод гадаад хамтын ажиллагааны хүрээнд аймаг, орон нутгаа сурталчлан таниулах үйл ажиллагааны зардалд зориулж, 4,070,000 (дөрвөн сая далан мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
12 дугаар сарын 07-ны
А/628 дугаар захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Бэлгийн багц 1	50	28,600	1,430,000
2	Бэлгийн багц 2	50	52,800	2,640,000
	Дүн			4,070,000